



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгөнд бүртгэж
авах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдын хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08 дугар сарын 09-ний өдрийн 95 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/1093 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй байсан 68,724,582.80 (жаран найман сая долоон зуун хорин дөрвөн мянга таван зуун наян хоёр арваны ная) төгрөгний үлдэх өртөг бүхий 2 дугаар хорооны хуучин барилгыг байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд авсугай.

2. Үндсэн хөрөнгөнд бүртгэж авах барилгын мэдээллийг хавсралтаар баталсугай.

3. Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлд балансаас балансад шилжиж ирсэн барилгыг зохих журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авахыг нягтлан бодогч /Б.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг нярав /Б.Энхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн менежер, дотоод хяналтын ажилтан /Г.Гантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2023 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
А/32 тушаалын хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Барилга	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	2 дугаар хорооны хуучин барилга	БХД 2-р хороо	20003	ш	1	76,971,582.8	8,246,955.06	68,724,627.74



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Барилга балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 68,724,582.80 (жаран найман сая долоон зуун хорин дөрвөн мянга таван зуун наян хоёр аравны наян) төгрөгийн үлдэх өртөг бүхий 2 дугаар хорооны хуучин барилгыг Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвд, Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн балансад бүртгэлтэй 30,163,145.56 (гучин сая нэг зуун жаран гурван мянга нэг зуун дөчин тав аравны тавин зургаа) төгрөгийн үлдэх өртөг бүхий авто гражийн барилгыг Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургуулийн балансад хавсралтын дагуу шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ



№	Барилга байгуулам-жийн нэр	Байршил	Ашиглалт өд орсон он	Талбайн хэмжээ (м/кв)	Барилгын хийц	Нийт үнэ	Хуримтлагад-сан элэгдэл (2023.06.01 байдлаар)	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	2 дугаар хорооны хуучин барилга	Багахангай дүүргийн 2 дугаар хороо	2003	144,3	Тоосго болон блокон дүүргэгч ханатай, цутгамал бетон суурьтай, модон шувуу нуруу бүхий төмөр дээвэртэй.	76,971,582.80	8,246,955.06	68,724,627.74	Багахангай дүүргийн ЗДТГ	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв
2	Авто гражийн барилга	Багануур дүүргийн 1 дүгээр хороо	1986	83,16	Тоосгон дүүргэгч ханатай, цутгамал бетон суурьтай, цутгамал бетон хавтгай дээвэртэй.	32,608,806.10	2,445,660.54	30,163,145.56	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	Нийслэлийн ерөнхий боловсролы Гүн галуутай Цогцолбор сургууль
Дүн						109,580,388.9	10,692,615.60	98,887,773.30		



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/1093

Улаанбаатар хот

Балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78 дугаар 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн балансад бүртгэлтэй, нийт 109,580,388.90 (нэг зуун есөн сая таван зуун наян мянга гурван зуун наян найман мянган төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2 барилгыг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлэн, данс бүртгэлээсээ хасахыг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т тус тус зөвшөөрсүгэй.

2.Балансаас балансад шилжин ирж буй хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв (Х.Ганбат), Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургууль (Б.Алтансарнай)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСАЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нийт үнэ	Хуримтлагад сан элэгдэл (2023.06.01)	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	2 дугаар хорооны хуучин барилга	БХД, 2-р хороо	2003	ш	1	76,971,582.8	8,246,955.06	68,724,627.74	Багахангай дүүргийн ЗДТГ	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв
2	Авто гражийн барилга	БНД, 1-р хороо	1986	ш	1	32,608,806.10	2,445,660.54	30,163,145.56	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	Нийслэлийн ерөнхий боловсролын Гүн галуттай цогцолбор сургууль
Дүн						109,580,388.9				

